

## **ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

### **НЭГ. ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ БОЛСОН ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА**

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүл мэндийн тухай хууль нь 2011 онд батлагдсанаас хойш нийт 31 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсны улмаас зохицуулалтын уялдаа холбоо алдагдаж, салбарын хөгжлийг цогцоор нь чиглүүлэх системийн шинж чанар сул болсон байна. Үүний улмаас эрүүл мэндийн салбарын бодлого, зохицуулалт, хэрэгжилт хоорондын уялдаа хангалтгүй болж, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашигт сөргөөр нөлөөлөх нөхцөл бүрдээд байна.

Монгол Улсын Үндсэн хуульд иргэн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхийг баталгаажуулсан бөгөөд төрөөс иргэдийнхээ өмнө уг эрхийг хангах үүргийг хүлээдэг. Түүнчлэн “Алсын хараа–2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нотолгоонд суурилсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, дижитал эрүүл мэндийн хөгжлийг эрчимжүүлэх зорилтыг дэвшүүлсэн нь салбарын эрх зүйн орчныг шинэчлэх бодит шаардлагыг бий болгож байна.

Эрүүл мэндийн салбарын өнөөгийн тогтолцоонд дүн шинжилгээ хийхэд хэд хэдэн суурь шинжтэй хүндрэл, доголдол илэрч байна. Нэгдүгээрт, нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ, эм зүйн тусламж үйлчилгээ хоорондын уялдаа сул, эмнэлэг төвтэй загвар давамгайлж, урьдчилан сэргийлэх бодлого хангалтгүй хэрэгжиж байна. Хоёрдугаарт, санхүүжилтийн тогтолцоо тогтворгүй, иргэдийн халааснаас гарах зардал олон улсын зөвлөмжөөс давсан өндөр түвшинд хүрч, эрүүл мэндийн даатгалын сангийн алдагдал нэмэгдсэн нь тогтолцооны тогтвортой байдалд эрсдэл үүсгэж байна. Гуравдугаарт, засаглал, удирдлагын тогтолцоо сул, ялангуяа төрийн өмчит эмнэлгүүдийн төлөөлөн удирдах зөвлөлийн тогтолцоо бодит байдал дээр бүрэн хэрэгжихгүй, удирдлагын томилгоонд улс төрийн нөлөө их байсаар байна.

Дөрөвдүгээрт, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлого оновчгүй, хөдөө орон нутагт мэргэжилтний хомсдол үүсэж, ажлын ачаалал, сэтгэл зүйн дарамт нэмэгдсэн нь үйлчилгээний чанарт нөлөөлж байна. Тавдугаарт, эм зүйн салбарын эрх зүйн зохицуулалт нь эмийн хангамжийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэг хэсэг бус, худалдааны хэлбэрээр зохицуулж байгаа нь эмийн үнэ, хүртээмжийн асуудлыг хүндрүүлж байна. Зургаадугаарт, дижитал эрүүл мэндийн хөгжлийг дэмжих эрх зүйн орчин бүрдээгүй, телемедицин, эрүүл мэндийн мэдээллийн систем, мэдээллийн аюулгүй байдлын зохицуулалт хангалтгүй байна.

Дээр дурдсан нөхцөл байдлаас үзэхэд эрүүл мэндийн салбарын эрх зүйн зохицуулалтыг хэсэгчилсэн байдлаар бус, харин тогтолцооны түвшинд шинэчлэн боловсронгуй болгох шаардлага үүссэн байна. Иймд Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, салбарын бодлого, зохицуулалт, хэрэгжилтийг нэгдмэл тогтолцоонд оруулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх, иргэдийн эрүүл мэндийн эрхийг бодитой хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор энэхүү хуулийн төслийг боловсрууллаа.

Шинэчилсэн найруулгын хүрээнд эрүүл мэндийн тогтолцоог “эмнэлэг төвтэй” загвараас “нийгмийн эрүүл мэнд төвтэй” тогтолцоо руу үе шаттайгаар шилжүүлэх, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих бодлогыг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх суурь өөрчлөлтийг тусгахыг эрмэлзлээ.

## **ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦАА, ХАМРАХ ХҮРЭЭ**

Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зорилго нь Монгол Улсын иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах Үндсэн хуулиар баталгаажсан эрхийг бодитой хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд оршино. Энэ хүрээнд эрүүл мэндийн салбарын бодлого, зохицуулалтыг салангид бус, харилцан уялдаа бүхий нэгдмэл тогтолцоонд оруулах, санхүүжилт, хүний нөөц, технологи, удирдлага, зохион байгуулалтын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг уялдуулан зохицуулах, улмаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Хуулийн төсөл нь эрүүл мэндийн тогтолцооны үндсэн харилцааг цогцоор нь зохицуулах зорилготой бөгөөд үүнд эрүүл мэндийн тогтолцооны бүтэц, удирдлага, зохион байгуулалт, нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн тусламж, үйлчилгээний уялдаа, санхүүжилт болон эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, салбарын хүний нөөцийн бодлого, дижитал эрүүл мэндийн хөгжүүлэлт, түүнчлэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоотой холбоотой харилцаа хамаарна. Ийнхүү эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааг зөвхөн үйлчилгээ үзүүлэх хүрээнд бус, бодлогоос хэрэгжилт, үнэлгээ хүртэлх бүх үе шатыг хамарсан нэгдсэн зохицуулалтад оруулж байгаагаараа онцлогтой.

Мөн хуулийн төсөл нь төр, орон нутгийн байгууллага, эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн ажилтан, иргэн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдагч зэрэг оролцогч талуудын хооронд үүсэх харилцааг бүхэлд нь хамарна. Энэ нь эрүүл мэндийн салбар дахь оролцогч талуудын үүрэг, хариуцлага, харилцан уялдааг тодорхой болгож, тогтолцооны үр ашиг, ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн.

## **ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ БҮТЭЦ, БҮЛЭГ ТУС БҮРЭЭР ЗОХИЦУУЛСАН АГУУЛГА**

Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь нийт 9 бүлэг, 50 зүйлээс бүрдэх бөгөөд эрүүл мэндийн салбарын бодлого, зохицуулалтыг системийн түвшинд цогцоор нь шинэчлэхэд чиглэсэн. Хуулийн төслийн бүлэг тус бүр нь эрүүл мэндийн тогтолцооны үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг уялдаа холбоотойгоор зохицуулж, салбарын үйл ажиллагааг нэгдмэл, тогтвортой, үр дүнтэй байлгах эрх зүйн суурийг бүрдүүлэх зорилготой.

Хуулийн төслийн Нэгдүгээр бүлэгт эрүүл мэндийн салбарын эрх зүйн зохицуулалтын суурь ойлголт, зорилт, зарчим, нэр томъёог тодорхойлсон. Энэ бүлгээр дамжуулан иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах үндсэн эрхийг хангах хүрээнд төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчмыг тогтоож, эрүүл мэндийн тогтолцоог бүхэлд нь хамарсан зохицуулалтын хүрээг тодорхойлсон. Мөн эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн бүрэлдэхүүн, бусад холбогдох хуулиудтай уялдах зарчмыг тогтоож, нэр томъёоны нэгдмэл ойлголтыг бий болгосон.

Түүнчлэн уг бүлэгт эрүүл мэндийн салбарт баримтлах бодлого, зарчмыг тодорхойлохдоо хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, шинжлэх ухааны нотолгоонд тулгуурлах, нийгмийн эрүүл мэндийг тэргүүлэх чиглэл болгох, эрүүл мэндийн байгууллагын бие даасан байдлыг хангах, салбар дундын оролцоог дэмжих зэрэг орчин үеийн эрүүл мэндийн бодлогын суурь зарчмуудыг тусгасан. Ялангуяа нотолгоонд суурилсан анагаах ухаан, дижитал эрүүл мэнд, эрүүл мэндийн технологийн үнэлгээ зэрэг ойлголтыг хуульд тусгасан нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн.

Хуулийн төслийн Хоёрдугаар бүлэгт эрүүл мэндийн тогтолцоог нэгдмэл системийн хүрээнд тодорхойлон, түүний бүтэц, үйл ажиллагааны үндсэн зарчим, төрийн үүрэг, бодлого төлөвлөлтийн суурь шаардлагыг тусгасан. Энэ бүлгээр эрүүл мэндийн салбарыг салангид хэсгүүдийн нийлбэр бус, харин харилцан уялдаа бүхий цогц тогтолцоо гэж үзэх хандлагыг хуульчлан баталгаажуулж байгаагаараа онцлогтой.

Эрүүл мэндийн тогтолцоог хүн амын эрүүл мэндийг хамгаалах, бэхжүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, чанартай тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн нэгдмэл систем гэж тодорхойлж, уг тогтолцоо нь удирдлага, зохион байгуулалт, нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн болон эм зүй тусламж, үйлчилгээ, хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл, технологи, мэдээлэл, цахимжилт, санхүүжилт, даатгал зэрэг үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэж байхаар зохицуулсан. Эдгээр бүрэлдэхүүн хэсгийг салангид бус, харин харилцан уялдаа, залгамж чанартайгаар

төлөвлөж, хэрэгжүүлж, үнэлэх шаардлагыг хуульчилсан нь салбарын бодлого, шийдвэр гаргалтыг илүү системтэй болгох ач холбогдолтой.

Түүнчлэн төрөөс эрүүл мэндийн тогтолцооны хэвийн, тасралтгүй, үр нөлөөтэй ажиллагааг хангах үүргийг тодорхойлж, тогтолцооны аль нэг бүрэлдэхүүн хэсгийг орхигдуулах, зохицуулалтгүй орхих, эсхүл санхүүжилт, хүний нөөц, чадавхын тэнцвэрийг алдагдуулахыг хориглосон. Энэ нь эрүүл мэндийн салбарт урт хугацаанд үүсэж ирсэн салангид хөгжлийн асуудлыг таслан зогсоож, тогтолцооны тэнцвэрийг хадгалах эрх зүйн баталгааг бий болгохыг зорьсон.

Энэ бүлэгт эрүүл мэндийн салбарын бодлого, төлөвлөлтийг тогтолцоонд суурилсан байдлаар хэрэгжүүлэх шаардлагыг тусгайлан зааж, аливаа бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө нь эрүүл мэндийн тогтолцооны бүх бүрэлдэхүүн хэсгийн уялдаа холбоонд тулгуурласан байх зарчмыг тогтоосон. Түүнчлэн тогтолцооны аль нэг хэсэгт хийх өөрчлөлт нь бусад хэсэгт үзүүлэх нөлөөллийг урьдчилан үнэлэх шаардлагыг хуульчилсан нь бодлогын шийдвэр гаргалтын чанарыг сайжруулах, алдаа, зөрчлийг бууруулахад чухал ач холбогдолтой.

Мөн эрүүл мэндийн тогтолцооны тэсвэртэй, тогтвортой байдлыг хангах асуудлыг тусгасан бөгөөд халдварт өвчин, гамшиг, онцгой нөхцөл байдал, нийгэм, эдийн засгийн хямралын үед тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, эрсдэлийн үнэлгээ, бэлэн байдлыг тогтмол хангах бодлогыг хэрэгжүүлэхээр зохицуулсан. Түүнчлэн эрүүл мэндийн тогтолцооны тэгш, хүртээмжтэй байдлыг хангах зарчмыг тодорхойлж, хүн амын нийгэм, эдийн засгийн байдал, оршин суугаа газар, нас, хүйс, хөгжлийн бэрхшээл зэрэг хүчин зүйлээс үл хамааран эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжийг хангах, эмзэг бүлгийн хэрэгцээнд нийцсэн зохион байгуулалт, санхүүжилтийг бий болгохыг зорьсон. Эцэст нь эрүүл мэндийн тогтолцооны үйл ажиллагаа, гүйцэтгэл, үр нөлөөг тогтмол үнэлж, сайжруулах тогтолцоог бүрдүүлэхээр тусгасан бөгөөд уг үнэлгээг чанар, хүртээмж, үр ашиг, тэгш байдлын шалгуурт тулгуурлан хийх, түүний үр дүнг бодлого боловсруулах, санхүүжилт, зохицуулалтын шийдвэр гаргахад заавал харгалзан үзэхээр хуульчилсан.

Гуравдугаар бүлэгт эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог тодорхойлж, төрийн төв болон орон нутгийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрх, чиг үүргийн хуваарийг хуульчилсан.

Хуулийн төсөлд эрүүл мэндийн удирдлагын тогтолцоонд Улсын Их Хурал, Засгийн газар, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, эм зүйн тусламж хариуцсан төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга,

аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар болон эрүүл мэндийн байгууллагын удирдлагыг хамруулсан. Ингэснээр эрүүл мэндийн салбарын удирдлага зөвхөн төв байгууллагын хүрээнд бус, үндэсний, салбарын, орон нутгийн болон байгууллагын түвшинд харилцан уялдаатай хэрэгжих эрх зүйн үндэс бүрдэнэ.

Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах, батлагдсан бодлого, хөтөлбөрийг санхүүжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэнд санхүүжилт олгох журмыг батлах зэрэг чиг үүргийг тодорхойлсон.

Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг салбарын бодлого, төлөвлөлт, мэргэжил-арга зүйн удирдлага, мэдээлэл, хүний нөөц, чанар, магадлан итгэмжлэл, сургалт, судалгаатай холбоотой өргөн хүрээнд тодорхойлсон. Тухайлбал, хүн амын эрүүл мэндийн байдлыг судлах, хянах, үнэлэх, эрэлт хэрэгцээнд үндэслэн салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлэх, давтан сургах бодлогыг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн статистик мэдээллийг нэгтгэх, чанарын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох зэрэг чиг үүргийг тусгасан. Энэ нь эрүүл мэндийн бодлогыг нотолгоо, мэдээлэл, судалгаанд тулгуурлан боловсруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

Мөн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхийг хүн амын эрүүл мэндийг хамгаалах үндэсний хөтөлбөр, төсөл боловсруулах, салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах, санхүүжилт, төсвийн бодлогыг төлөвлөх, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн бодлогыг холбогдох байгууллагатай хамтран тодорхойлох, тусламж үйлчилгээний байршил, бүтэц, зохион байгуулалт, төрөл, шатлал, орны дээд хязгаарыг тогтоох зэрэг чиглэлээр нарийвчлан зохицуулсан. Түүнчлэн эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг, төр-хувийн хэвшлийн түншлэл, нэн шаардлагатай тусламж үйлчилгээний багц, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн мэргэжил арга зүйн чиг үүргийг зохицуулах асуудлыг тусгасан.

Орон нутгийн түвшинд аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг дарга, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын бүрэн эрхийг тодорхойлсон. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн асуудлаар Засаг даргын тайлан, мэдээллийг хэлэлцэх, орон нутгийн хөтөлбөр, шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавих, төрийн болон төрийн бус байгууллага, иргэний оролцоог хангах чиг үүрэгтэй байна. Энэ нь эрүүл мэндийн

бодлогыг орон нутгийн хэрэгцээ, хүн амын онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

Бүх шатны Засаг даргын хувьд харьяалах нутаг дэвсгэрт эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих хөтөлбөр, төсөл боловсруулах, эрүүл мэндийн байгууллагын бүтэц, байршил, материаллаг бааз, хүний болон санхүүгийн нөөцийг зохистой хуваарилах, онцгой нөхцөл байдалд шуурхай арга хэмжээ авах, эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиг үүргийг тусгасан. Энэ нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг орон нутгийн түвшинд бодитоор хангах эрх зүйн үндэс болно.

Дөрөвдүгээр бүлэгт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тогтолцоог цогцоор нь тодорхойлж, түүнийг нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эмнэлгийн тусламж үйлчилгээ, эм зүйн тусламж үйлчилгээ гэсэн гурван үндсэн төрөлтэй байхаар тусгасан. Ингэснээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зөвхөн эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хүрээнд бус, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эмийн чанар, аюулгүй байдал, зохистой хэрэглээг хангах өргөн хүрээтэй нэгдмэл тогтолцоо гэж үзэх эрх зүйн үндэс бүрдэнэ.

Энэ бүлгийн нэг гол шинэчлэл нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн тогтолцооны тэргүүлэх чиглэл болгон зохион байгуулах зохицуулалт юм. Үүний хүрээнд Ерөнхий сайдын дэргэд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл ажиллахаар тусгаж, нийгмийн эрүүл мэндийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг салбар хоорондын хамтын ажиллагаа, оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэхээр зохицуулсан. Уг зөвлөлөөр дамжуулан эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчин, санхүү, хууль зүй, онцгой байдлын салбарын бодлогын уялдааг хангах, Засгийн газрын богино болон дунд хугацааны хөтөлбөрт тусгагдсан нийгмийн эрүүл мэндийн зорилтот шалгуур үзүүлэлтийн биелэлтэд хяналт тавих боломж бүрдэнэ.

Мөн нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлж, халдварт болон халдварт бус өвчний тандалт, хяналт, дархлаажуулалт, урьдчилан сэргийлэлт, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, судалгааны тогтолцоог хөгжүүлэх, хүрээлэн буй орчин, хүнс, усны эрүүл ахуйн шаардлагын биелэлтэд хяналт тавих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр зохицуулсан. Энэ нь “өвдсөн хойно эмчлэх” бус, “өвчлөхөөс өмнө урьдчилан сэргийлэх” бодлогыг төрийн байгуулалтын түвшинд хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл болно.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хувьд хуулийн төсөлд шаталсан зохион байгуулалтыг тодорхойлж, анхан, хоёрдогч, гуравдагч шатлалын тусламж, үйлчилгээний уялдаа холбоог хангахаар тусгасан. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг эмнэлгийн тусламж, үйлчилгээний суурь байгууллага гэж үзсэн нь иргэн бүрд ойр, хүртээмжтэй, тасралтгүй тусламж хүргэх бодлогын ач холбогдолтой. Мөн эмнэлгийн тусламж, үйлчилгээний бодлогын хэрэгжилт, зохион байгуулалт, зохицуулалтыг хариуцах төрийн захиргааны байгууллагыг тодорхойлж, эмнэлгийн тусламжийн шатлал хоорондын уялдаа, орон нутгийн хэрэгжилт, гамшиг, онцгой нөхцөл байдлын үеийн бэлэн байдлыг хангах чиг үүргийг хуульчилсан.

Түүнчлэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, шаардлагад үндэслэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний сүлжээ, хүчин чадал, үйлчилгээний төрөл, хүний нөөцийн хэрэгцээг тогтмол тодорхойлох, эмнэлгийн тусламж, үйлчилгээний төлөвлөлтийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн технологийн үнэлгээг зохион байгуулах, тусгай зөвшөөрөл олгох асуудалд мэргэжлийн дүгнэлт гаргах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх чиг үүрэгтэй байхаар тусгасан. Энэ нь эмнэлэг, тоног төхөөрөмж, хүний нөөц, тусгай зөвшөөрлийн шийдвэрийг хүн амын бодит хэрэгцээ, шинжлэх ухааны нотолгоонд үндэслэн гаргах суурь зохицуулалт болно.

Эм зүйн тусламж, үйлчилгээний хувьд уг бүлэгт эм, вакцин, эмнэлгийн хэрэгслийг зөвхөн худалдаа, ханган нийлүүлэлтийн бүтээгдэхүүн бус, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг гэж үзэх үзэл баримтлалыг тусгасан. Эм зүйн тусламж, үйлчилгээ нь хүн амыг чанартай, аюулгүй, үр нөлөөтэй эм, вакцин, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангах, тэдгээрийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд чиглэхээр тодорхойлогдсон. Үүнд үйлдвэрлэл, импорт, экспорт, ханган нийлүүлэлт, хадгалалт, түгээлт, худалдаа, чанар, аюулгүй байдлын хяналт, эмийн үнийн зохицуулалт, зохистой хэрэглээ, эрүүл мэндийн технологийн үнэлгээ зэрэг харилцаа хамаарна.

Дөрөвдүгээр бүлэг нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тогтолцоог нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, эм зүйн тусламж, үйлчилгээ гэсэн гурван тулгуурт үндэслэн зохион байгуулж, тэдгээрийн уялдаа, залгамж чанарыг хангах эрх зүйн үндсийг бүрдүүлнэ. Эдгээр зохицуулалт нь эрүүл мэндийн салбарыг эмнэлэг төвтэй загвараас хүн амын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, чанартай эмчилгээ, аюулгүй эмийн хэрэглээг нэгтгэсэн нийгмийн эрүүл мэнд төвтэй тогтолцоо руу шилжүүлэхэд чиглэсэн чухал шинэчлэл болно.

Тавдугаар бүлэгт эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог бүхэлд нь шинэ үзэл баримтлалаар тодорхойлж, санхүүжилтийг зөвхөн төсөв, даатгалын эх үүсвэрийн

асуудал бус, иргэнийг эрүүл мэндийн зардлаас үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс хамгаалах, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашиг, тогтвортой байдлыг хангах бодлогын гол хэрэгсэл гэж үзсэн.

Энэ бүлгээр эрүүл мэндийн санхүүжилтийг нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эмнэлгийн тусламж үйлчилгээ, эм зүйн тусламж үйлчилгээний санхүүжилттэй уялдуулан зохицуулж, эх үүсвэрийг бүрдүүлэх, хуваарилах, зарцуулахад ил тод, хариуцлагатай, үр ашигт суурилсан зарчим баримтлахыг тусгасан. Мөн санхүүжилтийн тогтолцоо нь нас, нийгмийн байдал, газарзүйн байршлаас үл хамааран бүх иргэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүгийн хүртээмжийг тэгш хангахад чиглэхээр зохицуулсан.

Хуулийн төсөлд эрүүл мэндийн санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөв, эрүүл мэндийн даатгал, орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сан, олон улсын болон дотоодын хандив, тусламж, эрүүл мэндийн байгууллагын төлбөртэй тусламж, үйлчилгээний орлого болон хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэхээр тодорхойлсон. Тухайн жилийн санхүүжилтийн тэргүүлэх чиглэлийг тогтоохдоо хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, өвчлөлийн дарамт, нийгмийн эмзэг бүлгийн хэрэгцээг харгалзахаар тусгасан нь санхүүжилтийг бодит хэрэгцээ, нийгмийн шударга ёсны зарчимтай уялдуулах ач холбогдолтой.

Мөн эрүүл мэндийн салбарын нийт санхүүжилтийн хэмжээг дотоодын нийт бүтээгдэхүүний 5-аас доошгүй хувьд хүргэх зорилтыг тусгаж, уг хэмжээг үе шаттай хэрэгжүүлэхээр зохицуулсан. Үүний зэрэгцээ эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, анхан шатны тусламжийн санхүүжилт, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах арга хэмжээний санхүүжилт, орон нутгийн нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээний санхүүжилт, хөрөнгө оруулалт, бодлого удирдлагын зардлыг тооцох аргачлалыг нарийвчлан тогтоосон. Энэ нь эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг жил бүрийн төсвийн хэлэлцүүлгийн хүрээнд тохиолдлын байдлаар бус, урьдчилан тооцоолсон, тогтвортой эх үүсвэрт тулгуурлан төлөвлөх нөхцөлийг бүрдүүлнэ.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн хувьд үндсэн эх үүсвэр нь улсын болон орон нутгийн төсөв байхаар тусгаж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, дархлаажуулалт, эрүүл мэндийг дэмжих, ноцтой байдлын бэлэн байдал, үндэсний хэмжээний судалгаа, үнэлгээ зэрэг үйл ажиллагааг тодорхой эх үүсвэрээр санхүүжүүлэхээр зохицуулсан. Ингэснээр нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг үлдэгдэл санхүүжилтээр бус, тусгайлан төлөвлөсөн эх үүсвэрээр хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн хувьд эрүүл мэндийн даатгалын байгууллага нэг худалдан авагчийн зарчимд үндэслэн стратегийн худалдан авалтыг хэрэгжүүлэхээр тусгасан. Энэ хүрээнд өвчтөнд хэрэгцээтэй үед нь шаардлагатай, тэгш хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх, эмнэлгийн байгууллагын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, сангийн тэнцлийг хадгалах, үргүй зардлыг бууруулах, тусламж, үйлчилгээний үр дүн, гүйцэтгэлийг сайжруулах санхүүгийн удирдлага, төлбөрийн зохистой арга, хөшүүргийг хэрэглэхээр зохицуулсан.

Анхан шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээг иргэн эрүүл мэндийн даатгалтай эсэхээс үл хамааран бүрэн авах эрхтэй байхаар тусгаж, уг тусламж, үйлчилгээнд иргэнээс төлбөр авахыг хориглосон нь хүн амын эрүүл мэндийн суурь хамгаалалтыг бэхжүүлэх ач холбогдолтой. Харин хоёрдогч болон гуравдагч шатлалын тусламж, үйлчилгээний хувьд улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын эх үүсвэрээр санхүүжүүлэх хүрээг тодорхойлж, жирэмсэн, төрөлт, төрсний дараах тусламж, яаралтай болон түргэн тусламж, халдварт өвчин, гамшгийн үеийн тусламж, сүрьеэ, сэтгэцийн эмгэг зэрэг нийгмийн өндөр ач холбогдол бүхий тусламж, үйлчилгээг даатгалын байдлаас үл хамааран үнэ төлбөргүй үзүүлэхээр тусгасан.

Мөн шатлал хоорондын илгээх, эргэн мэдээлэх, хянах зохицуулалтыг сайжруулж, иргэн өөрөө шатлал алгасан тусламж авах, эсхүл амбулаториор эмчлэх боломжтой өвчнөөр эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх тохиолдолд нэмэлт хамтын төлбөр төлөх зарчим тусгасан. Энэ нь эмнэлгийн орны зохисгүй ашиглалт, өндөр өртөгтэй тусламжийн үргүй зарцуулалтыг бууруулж, санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Эм зүйн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн хүрээнд иргэн бүр шаардлагатай эмийг аюулгүй, чанартай, хүртээмжтэй, хямд өртөгтэй авах нөхцөлийг бүрдүүлэхийг зорьсон. Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний эмийн үнийн хөнгөлөлт, дархлаажуулалтын эм, бэлдмэл, сүрьеэ, ХДХВ, гепатитын эмчилгээний эм, жирэмсэн эмэгтэй, хүүхдэд шаардлагатай амин дэм, бичил тэжээлийн бэлдмэл, эрхтэн шилжүүлэн суулгасны дараах дархлаа дарангуйлах эм, сэтгэцийн эмгэгийн урт хугацааны эмчилгээний зайлшгүй шаардлагатай эмийн санхүүжилтийг тодорхой эх үүсвэрээр шийдвэрлэхээр тусгасан.

Түүнчлэн улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг төвлөрсөн байдлаар зохион байгуулах, чанар, аюулгүй байдал, үр нөлөө нь баталгаажсан ерөнхий нэршлийн эмийг патентлагдсан эмтэй тэгш нөхцөлөөр оролцуулах, эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх эмийн хөнгөлөлтийн жагсаалтад олон эх үүсвэртэй эмийг тэргүүн ээлжид бүртгэхээр зохицуулсан. Энэ нь эмийн үнийг бууруулах, эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх, улсын төсөв болон даатгалын сангийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн зохицуулалт юм.

Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн хувьд шинэ барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг эрүүл мэндийн технологийн үнэлгээ, хүн амын хэрэгцээний шинжилгээнд үндэслэн шийдвэрлэхээр тусгасан. Ингэснээр хөрөнгө оруулалтыг улс төрийн болон богино хугацааны шийдвэрээр бус, бодит хэрэгцээ, үр ашиг, хүртээмжийн үндэслэлтэйгээр төлөвлөх боломж бүрдэнэ. Мөн хөрөнгө оруулалтын дараах үйл ажиллагааны зардлыг урьдчилан тооцож, санхүүжилтийн эх үүсвэрийг баталгаажуулах шаардлага тавьсан нь барилга, тоног төхөөрөмжийн ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Эцэст нь эрүүл мэндийн санхүүжилтийн үр ашиг, ил тод байдлыг хангах зохицуулалтыг тусгаж, санхүүжилтийг төлөвлөх, хуваарилах, зарцуулахад үр ашиг, ил тод байдал, хариуцлагын зарчим баримтлах, санхүүжилтийн зардал болон хүн амын эрүүл мэндийн үр дүнгийн үзүүлэлтээр үнэлэх, санхүүжилттэй холбоотой мэдээллийг нэгдсэн цахим тогтолцоогоор нийтэд нээлттэй байлгах, иргэний гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариуцлага тооцох журмыг бүрдүүлэхээр зохицуулсан.

Ийнхүү Тавдугаар бүлэг нь эрүүл мэндийн санхүүжилтийг тогтвортой, ил тод, үр ашигтай, иргэн төвтэй болгох, улсын төсөв, эрүүл мэндийн даатгал, орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрийг уялдуулах, иргэнийг эрүүл мэндийн зардлаас үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс хамгаалах, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнг санхүүжилтийн бодлоготой холбох эрх зүйн үндсийг бүрдүүлж байна.

Зургаадугаар бүлэгт эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлогыг тогтолцооны түвшинд төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх эрх зүйн үндсийг тусгасан. Энэ бүлгийн гол зорилго нь эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийг зөвхөн тухайн үеийн сул орон тоог нөхөх байдлаар бус, хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, тусламж үйлчилгээний бүтэц, нутаг дэвсгэрийн онцлог, үйлчилгээний ачаалалтай уялдуулан урт хугацаанд төлөвлөхөд оршино.

Хуулийн төсөлд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн улсын хэмжээнд эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийг зохистой байлгах нэгдсэн төлөвлөгөөг дөрвөн жилээр боловсруулж, хэрэгжүүлэхээр тусгасан. Уг төлөвлөгөөнд хүний нөөцийн бодлогын зорилго, зорилт, эрэлт хэрэгцээний төсөөлөл, эрүүл мэндийн ажилтныг бэлтгэх, хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэх бодлого, мэргэшүүлэх болон давтан сургалт, хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн баталгаа, дутагдалтай болон ачаалалтай бүс нутагт хүний нөөцийг бэлтгэх, хуваарилах, тогтвортой ажиллуулах арга хэмжээг заавал тусгахаар зохицуулсан.

Мөн хүний нөөцийн нэгдсэн төлөвлөгөөг аймаг, нийслэлийн түвшинд хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр хамтран баталж хэрэгжүүлэх, аймаг, нийслэлийн

Засаг дарга хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр тайлагнах, уг тайланд үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хэрэгжилтийг үнэлж, дүгнэлтийг олон нийтэд мэдээлэхээр тусгасан. Энэ нь хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг зөвхөн төв байгууллагын түвшинд бус, орон нутгийн хариуцлага, оролцоотойгоор хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Түүнчлэн эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийн талаар дөрвөн жил тутам судалгаа хийж, олон нийтэд мэдээлэх зохицуулалтыг тусгасан. Энэхүү судалгаанд эрүүл мэндийн ажилтны бэлтгэл, хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэлт, зөвшөөрөлтэй ажилтны тоо, мэргэшил, давтан сургалтын байдал, аймаг, нийслэл, сум, дүүрэг болон байгууллага тус бүрийн хүний нөөцийн нөхцөл, үйлчилгээ дутмаг буюу хэт ачаалалтай бүс нутгийн хуваарилалт, ажлын нөхцөл, цалин хөлс, ачаалал, нийгмийн баталгаа, шилжилт хөдөлгөөн, ажилтны сэтгэл ханамж зэрэг үзүүлэлтийг хамруулахаар тусгасан. Энэ нь хүний нөөцийн бодлогыг бодит тоо мэдээлэл, судалгаанд тулгуурлан шинэчлэх ач холбогдолтой.

Долоодугаар бүлэгт дижитал эрүүл мэндийн бодлого болон эрүүл мэндийн мэдээллийн зохицуулалтыг орчин үеийн технологийн хөгжил, эрүүл мэндийн салбарын шинэ хэрэгцээтэй уялдуулан цогцоор нь тусгасан. Энэ бүлгийн үндсэн зорилго нь дижитал технологид суурилсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдал, нууцлал, зохистой ашиглалтыг хангахад оршино.

Хуулийн төсөлд дижитал эрүүл мэндийг хөгжүүлэх хүрээнд мобайл тусламж, үйлчилгээ, эрүүл мэндийн мэдээллийн систем, теле-эрүүл мэнд, теле-медицин, хиймэл оюун зэрэг технологийг ашиглан хүн бүрд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, бүтээгдэхүүнийг ашиглах боломжийг бүрдүүлэхээр тусгасан. Ингэснээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний газарзүйн болон цаг хугацааны хязгаарлалтыг бууруулж, алслагдсан бүс нутагт хүртээмжийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдэнэ.

Мөн дижитал эрүүл мэндийг дэмжих үндэсний тогтолцоог хөгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих, олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх зорилгоор жил бүр хэрэгжүүлэх төлөвлөгөөг улсын хөгжлийн дунд хугацааны бодлоготой уялдуулан баталж, хэрэгжилтийн тайланг олон нийтэд ил тод мэдээлэхээр зохицуулсан. Энэ нь дижитал эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг тасралтгүй, ил тод, хариуцлагатай байлгах ач холбогдолтой.

Дижитал эрүүл мэндийн үндэсний тогтолцоог бүрдүүлэх хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, программ хангамжид тавигдах шаардлага, үнэлгээний шалгуурыг тогтоож, шаардлага хангасан бүтээгдэхүүний жагсаалтыг олон

нийтэд нээлттэй байршуулан, эрүүл мэндийн байгууллагууд уг жагсаалтад багтсан систем, бүтээгдэхүүнийг ашиглах үүрэгтэй байхаар тусгасан. Энэ нь мэдээллийн системийн уялдаа холбоо, чанар, аюулгүй байдлыг хангах, салбарын хэмжээнд стандартчилах зорилготой зохицуулалт юм.

Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх зохицуулалт нь энэ бүлгийн гол хэсэг бөгөөд уг сан нь улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн даатгалын байгууллага зэрэг бүх эх үүсвэрээс мэдээлэл цуглуулж, боловсруулах, ашиглах, хадгалах, эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулах, бодлого боловсруулах, өвчтөний эрхийг хангах, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилготой байхаар тусгасан. Мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журмыг холбогдох байгууллагууд хамтран боловсруулж батлах бөгөөд энэ нь мэдээллийн аюулгүй байдлыг системийн түвшинд хангах нөхцөл болно.

Хуулийн төсөлд эрүүл мэндийн мэдээллийг үндсэндээ өвчтөний зөвшөөрлийн үндсэн дээр цуглуулах зарчмыг баримтлах боловч амь насанд аюултай нөхцөл байдал, яаралтай тусламж үзүүлэх шаардлагатай үед зөвшөөрөлгүйгээр мэдээлэл цуглуулах боломжийг тодорхойлсон. Энэ нь хувь хүний мэдээллийн нууцлал, хамгаалалтыг хангахын зэрэгцээ хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах шаардлагыг тэнцвэртэй хангах зохицуулалт юм.

Эрүүл мэндийн мэдээллийг нэгдсэн санд тогтмол дамжуулах үүргийг эрүүл мэндийн байгууллагад хүлээлгэж, шүүх шинжилгээний байгууллага нас баралтын шалтгааны мэдээллийг дамжуулах, шүүх, прокурорын шийдвэрийн дагуу тодорхой мэдээллийг шилжүүлэх зохицуулалтыг тусгасан. Энэ нь мэдээллийн бүрэн байдал, үнэн зөв байдлыг хангах, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаатай уялдуулах ач холбогдолтой.

Наймдугаар бүлэгт эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн бус байгууллагын оролцоог эрх зүйн хувьд тодорхойлж, эрүүл мэндийн салбарын бодлого, хэрэгжилтийг зөвхөн төрийн байгууллагын үүрэгт хязгаарлахгүйгээр нийгмийн бүх түвшний оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэх суурь зохицуулалтыг тусгасан.

Энэ хүрээнд иргэний эрүүл мэндээ хамгаалах эрх, үүргийг нарийвчлан тодорхойлсон. Иргэн нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах, өрхийн эмчээ сонгон бүртгүүлэх, өөрийн эрүүл мэндийн мэдээлэлтэй танилцах, оношилгоо, эмчилгээтэй холбоотой шийдвэрийг мэдээлэлд тулгуурлан гаргах, эрүүл мэндийн байгууллага, ажилтнаас мэдээлэл авах, эрүүл мэндтэй холбоотой мэдээллийн нууцыг хамгаалуулах

зэрэг эрх эдлэхээр тусгасан. Үүний зэрэгцээ иргэн нь эрүүл мэндийн боловсрол эзэмших, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дэглэмийг сахих, эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй нөхцөл байдлын талаар мэдээлэх, эрүүл мэндийн байгууллагын шаардлагыг биелүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдах, эрүүл мэндийн ажилтны үйл ажиллагаанд саад учруулахгүй байх зэрэг үүрэг хүлээхээр зохицуулсан. Энэ нь иргэнийг эрүүл мэндийн үйлчилгээний идэвхгүй хэрэглэгч бус, өөрийн болон нийгмийн эрүүл мэндийг хамгаалах идэвхтэй оролцогч болгох бодлогын ач холбогдолтой.

Мөн өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын үүргийг тодорхойлж, ажилтны эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, эрүүл ахуйн стандарт, хэм хэмжээг мөрдөх, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгө, нөөцийг төлөвлөх, осол, гэмтэл, халдвар, хордлогоос урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх, ажилтныг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах зэрэг үүргийг хуульчилсан. Түүнчлэн иргэн, байгууллагын зөвшөөрөлгүйгээр эрүүл мэндийн мэдээллийг олон нийтэд тараахыг хориглосон нь мэдээллийн нууцлал, хамгаалалтыг хангах чухал зохицуулалт юм.

Төрийн бус байгууллагын оролцоог дэмжих хүрээнд эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт тавих, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах, сургалт, сурталчилгаа, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулах боломжийг тусгасан. Мөн зарим төрлийн ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжийг нээж, тэдгээрт тавих шаардлага, шалгуурыг тогтоох эрхийг холбогдох төрийн байгууллагад олгосон нь төр, иргэний нийгмийн түншлэлийг бэхжүүлэх ач холбогдолтой.

Салбар дундын хамтын ажиллагааны зохицуулалтаар хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлс нь зөвхөн эрүүл мэндийн салбараар хязгаарлагдахгүй тул бусад салбарын бодлого, үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлэх шаардлагыг хуульчилсан. Энэ хүрээнд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн байгууллага нь бусад салбарын байгууллагатай хамтран ажиллах, санал, зөвлөмж хүргүүлэх, хамтарсан бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах үүрэгтэй бөгөөд бусад байгууллага нь эдгээр санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, хамтарсан арга хэмжээнд оролцох үүрэг хүлээхээр тусгасан. Мөн хамтарсан арга хэмжээний санхүүжилтийг холбогдох байгууллагууд хамтран төлөвлөж, төсөвт тусган батлуулах зохицуулалтыг тусгасан нь бодлогын хэрэгжилтийг бодитой хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

Есдүгээр бүлэгт энэ хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй тохиолдолд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заасан. Мөн хуулийг 2027 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоосон нь шинэчлэн найруулсан хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бэлтгэл хангах хугацааг олгож байна.

## **ДӨРӨВ. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУРШЛАГА**

Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахдаа олон улсын байгууллагын зөвлөмж, хөгжингүй болон хөгжиж буй орнуудын туршлагыг харгалзан үзэж, эрүүл мэндийн тогтолцоог цогцоор нь шинэчлэх чиг хандлагад нийцүүлэн боловсруулсан.

Нэгдүгээрт, хуулийн төсөл нь World Health Organization-ийн тодорхойлсон эрүүл мэндийн тогтолцооны “6 блок” загварт тулгуурласан. Уг загварт эрүүл мэндийн тогтолцоог (i) үйлчилгээ үзүүлэлт, (ii) хүний нөөц, (iii) мэдээллийн тогтолцоо, (iv) эм, технологи, (v) санхүүжилт, (vi) удирдлага, засаглал гэсэн харилцан уялдаа бүхий бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдсэн нэгдмэл систем гэж үздэг. Хуулийн төсөлд эдгээр бүрэлдэхүүн хэсгийг салангид бус, уялдаа холбоотойгоор зохицуулж, бодлого, төлөвлөлт, үнэлгээг системийн түвшинд хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Хоёрдугаарт, эрүүл мэндийн санхүүжилтийн хувьд олон улсад өргөн хэрэглэгдэж буй стратегийн худалдан авалтын болон үр дүнд суурилсан төлбөрийн аргачлалуудыг тусгасан. Тухайлбал, даатгалын байгууллага нэг худалдан авагчийн зарчимд үндэслэн тусламж, үйлчилгээг худалдан авах, үйлчилгээний чанар, үр дүн, гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжилт олгох, оношилгоонд суурилсан буюу тохиолдолд суурилсан төлбөрийн тогтолцоог (case-based payment) хэрэглэх чиг хандлагыг тусгасан. Энэ нь санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэх, илүүдэл зардлыг бууруулах, үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн олон улсын сайн туршлагад нийцнэ.

Гуравдугаарт, дижитал эрүүл мэндийн бодлогын хувьд телемедицин, теле-эрүүл мэндийн үйлчилгээний зохицуулалтыг эрчимтэй хөгжүүлж буй БНХАУ болон Зүүн Өмнөд Азийн орнуудын туршлагыг харгалзан үзсэн. Эдгээр орнуудад алслагдсан бүс нутагт эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эмчийн зөвлөгөөг зайнаас хүргэх, мэдээллийн нэгдсэн системд суурилсан үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн байдаг. Хуулийн төсөлд дижитал эрүүл мэндийн үндэсний тогтолцоо, мэдээллийн нэгдсэн сан, программ хангамжийн стандарт, теле-медицин үйлчилгээний зохицуулалтыг тусгаснаар Монгол Улсад энэ чиглэлийн хөгжлийг дэмжих эрх зүйн суурь бий болж байна.

Дөрөвдүгээрт, нийгмийн эрүүл мэндийг тэргүүлэх чиглэл болгох бодлого нь олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн орнууд (OECD)-ын туршлагад тулгуурласан. OECD-ийн орнуудад эрүүл мэндийн зардлын өсөлтийг бууруулах, хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх, өвчлөлийг бууруулах зорилгоор урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх бодлогыг эрчимтэй хэрэгжүүлдэг. Хуулийн төсөлд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг бие даасан тогтолцоо болгон хөгжүүлэх, салбар дундын хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжүүлэх, тогтвортой санхүүжилтээр хангах зохицуулалтыг тусгасан нь энэ чиг хандлагатай нийцнэ.

## **ТАВ. ҮНДСЭН ХУУЛЬ БОЛОН БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖИЙН УЯЛДАА, ДАГАЛДАХ ӨӨРЧЛӨЛТ**

Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхийг хангах зорилготой бөгөөд Үндсэн хууль болон холбогдох салбарын хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулагдсан.

Хуулийн төсөл батлагдсантай холбогдуулан эрүүл мэндийн санхүүжилт, эрүүл мэндийн даатгал, эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллагын тогтолцоо, тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэл, эмнэлгийн байгууллагын удирдлага, зохион байгуулалттай холбоотой зарим харилцааг бусад хуультай уялдуулах шаардлага үүсэж байна.

Юуны өмнө Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхээр тусгасан. Энэ хүрээнд согтууруулах ундаа, тамхи, чихэр, чихэр орлуулагч агуулсан ундаа зэрэг эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх бүтээгдэхүүний онцгой албан татварын тодорхой хувийг эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах хувийг нэмэгдүүлнэ. Ингэснээр нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг тогтвортой санхүүжүүлэх боломж бүрдэнэ.

Мөн Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг шинэчилсэн найруулгын санхүүжилтийн зохицуулалттай уялдуулах шаардлагатай байна. Энэ нь эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын тогтвортой байдлыг хангах, нэг худалдан авагчийн зарчимд суурилсан стратегийн худалдан авалтыг хэрэгжүүлэх, иргэдийг эрүүл мэндийн зардлаас үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс хамгаалах бодлоготой уялдана.

Түүнчлэн Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт оруулж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын төрөл, чиг үүрэг, удирдлага, зохион

байгуулалт, тусгай зөвшөөрөл, дотоод хяналт, магадлан итгэмжлэлтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан тусгахаар байна.

Дагалдах хуулийн төслүүд нь Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үндсэн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилготой бөгөөд салбарын хууль тогтоомжийн уялдаа, хэрэгжилтийн нэгдмэл байдлыг хангахад чиглэнэ.

Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь эрүүл мэндийн салбарын эрх зүйн зохицуулалтыг хэсэгчилсэн байдлаар бус, тогтолцооны түвшинд цогцоор нь шинэчлэхэд чиглэсэн. Хуулийн төсөл батлагдсанаар иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах үндсэн эрхийг бодитой хэрэгжүүлэх эрх зүйн орчин сайжирч, эрүүл мэндийн тогтолцооны удирдлага, санхүүжилт, хүний нөөц, тусламж үйлчилгээ, эм зүй, дижитал эрүүл мэнд, мэдээллийн зохицуулалт харилцан уялдаатайгаар хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

—oo00oo—